| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,485,100.00 | 11,899,302.44 | 11,899,302.44 | 0.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,871,300.00 | 2,882,599.09 | 2,882,599.09 | 0.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,712,800.00 | 28,823,817.95 | 28,823,817.95 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **322,037,400.00** | **292,224,505.00** | **292,224,505.00** | **4,784,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,906,900.00 | 11,013,964.00 | 11,013,964.00 | 0.00 |
| 210302 | Түлш, халаалт | 308,053,500.00 | 279,133,541.00 | 279,133,541.00 | 0.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,077,000.00 | 2,077,000.00 | 2,077,000.00 | 4,784,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **88,102,200.00** | **85,260,961.00** | **85,260,961.00** | **1,000,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,557,900.00 | 5,557,900.00 | 5,557,900.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,960,500.00 | 39,928,300.00 | 39,928,300.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,628,500.00 | 8,714,430.00 | 8,714,430.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,737,500.00 | 3,647,000.00 | 3,647,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,850,700.00 | 5,046,300.00 | 5,046,300.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,367,100.00 | 22,367,031.00 | 22,367,031.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **110,596,500.00** | **108,989,560.00** | **108,989,560.00** | **0.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,226,600.00 | 43,619,660.00 | 43,619,660.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 61,354,000.00 | 61,354,000.00 | 61,354,000.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,015,900.00 | 4,015,900.00 | 4,015,900.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **107,337,700.00** | **98,583,350.00** | **98,583,350.00** | **0.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 31,160,000.00 | 30,800,000.00 | 30,800,000.00 | 0.00 |
| 210602 | Тавилга | 20,750,000.00 | 13,900,000.00 | 13,900,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 55,427,700.00 | 53,883,350.00 | 53,883,350.00 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **12,740,100.00** | **10,086,600.00** | **10,086,600.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,740,100.00 | 10,086,600.00 | 10,086,600.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,599,900.00** | **4,840,598.00** | **4,840,598.00** | **3,115,085.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,225,200.00 | 2,181,996.00 | 2,181,996.00 | 3,115,085.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,092,000.00 | 912,000.00 | 912,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 927,000.00 | 705,425.00 | 705,425.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,000,000.00 | 749,710.00 | 749,710.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 157,000.00 | 102,000.00 | 102,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 198,700.00 | 189,467.00 | 189,467.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **154,005,600.00** | **142,547,524.00** | **142,547,524.00** | **27,593,710.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 150,227,500.00 | 139,109,424.00 | 139,109,424.00 | 27,593,710.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,778,100.00 | 3,438,100.00 | 3,438,100.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,410,600.00** | **41,372,000.00** | **41,372,000.00** | **1,912,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **41,410,600.00** | **41,372,000.00** | **41,372,000.00** | **1,912,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,720,400.00 | 5,695,200.00 | 5,695,200.00 | 0.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,567,500.00 | 25,567,500.00 | 25,567,500.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,122,700.00 | 10,109,300.00 | 10,109,300.00 | 1,912,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **117,542,400.00** | **115,146,108.00** | **115,146,108.00** | **270,000.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 117,542,400.00 | 115,146,108.00 | 115,146,108.00 | 270,000.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **196,017,000.00** | **61,685,000.00** | **61,685,000.00** | **0.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 196,017,000.00 | 61,685,000.00 | 61,685,000.00 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,873,771,700.00** | **2,735,459,764.68** | **2,831,868,300.69** | **-627,997,636.01** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,490,269,800.00** | **1,490,269,900.00** | **2,355,782,400.00** | **-1,396,101,600.00** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,490,269,800.00 | 1,490,269,900.00 | 1,490,269,900.00 | -530,589,100.00 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **971,355,600.00** | **1,071,805,900.00** | **85,843,400.00** | **984,962,500.00** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 885,512,200.00 | 985,962,500.00 | 0.00 | 985,962,500.00 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 85,843,400.00 | 85,843,400.00 | 85,843,400.00 | -1,000,000.00 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **32,091,000.00** | **30,484,060.00** | **30,484,060.00** | **0.00** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 32,091,000.00 | 30,484,060.00 | 30,484,060.00 | 0.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **380,055,300.00** | **142,899,904.68** | **359,758,440.69** | **-216,858,536.01** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 134,096,800.00 | 119,984,404.68 | 119,984,404.68 | 0.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,070,000.00 | 22,915,500.00 | 22,915,500.00 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 96,408,536.01 | 0.00 | 96,408,536.01 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 127,034,932.69 | 0.00 | 127,034,932.69 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **778.00** | **778.00** | **0.00** | **778.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **6.00** | **6.00** | **0.00** | **6.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 6.00 | 6.00 | 0.00 | 6.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **121.00** | **121.00** | **0.00** | **121.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 12.00 | 12.00 | 0.00 | 12.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 78.00 | 78.00 | 0.00 | 78.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 31.00 | 31.00 | 0.00 | 31.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **530.00** | **530.00** | **0.00** | **530.00** |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **357.00** | **357.00** | **0.00** | **357.00** |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 357.00 | 357.00 | 0.00 | 357.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **173.00** | **173.00** | **0.00** | **173.00** |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 173.00 | 173.00 | 0.00 | 173.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **121.00** | **121.00** | **0.00** | **121.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11.00 | 11.00 | 0.00 | 11.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 3.00 | 3.00 | 0.00 | 3.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 25.00 | 25.00 | 0.00 | 25.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 74.00 | 74.00 | 0.00 | 74.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 1.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7.00 | 7.00 | 0.00 | 7.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | ТЕЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **238,481,614.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **238,481,614.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **197,303,614.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **88,407,527.00** |
| 210101 | Үндсэн цалин | 81,457,977.00 |
| 210102 | Нэмэгдэл | 6,949,550.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **11,420,094.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,420,094.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,784,000.00** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,784,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,946,119.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 996,685.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,200,000.00 |

| | | |
|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 809,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,940,434.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **49,825,379.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,325,379.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **837,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 837,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **474,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 474,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,115,085.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,115,085.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **29,493,710.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,593,710.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,900,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,178,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **40,712,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 38,800,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,912,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **466,000.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 466,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **238,481,614.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **238,481,614.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,652,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 61,538,814.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 154,290,700.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнзүйл сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.16-нөөс 2022.03.25–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.28-ны өдрийн 1/31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага 5, сан 3, ерөнхий орлогын данс нийт 10 тайлан нэгтгэджээ.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Есөнзүйл сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнзүйл сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 4 тэрбум 455.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 44.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 33.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 520.8 сая төгрөгөөр өссөн байна.

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Төрийн сангийн харилцах | 246.8 | 767.7 | 520.8 |

### 3.5.2 Авлага

| АВЛАГА | 2020 он | 2021 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.0 | 0.1 | 0.1 |
| Зээлийн хүүгийн авлага | 5.1 | 3.4 | -1.7 |
| Байгууллагаас авах авлага | 8.6 | 78.6 | 70.0 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 236.5 | 183.9 | -52.6 |
| **Дүн** | **250.1** | **266.0** | **15.9** |

Тайлант оны нийт авлагын 52.6 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь эрсдэлээс хамгаалах сан, сум хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 128.3 сая төгрөгөөр өссөн байна.

| Бараа материал | 2020 он | 2021 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Тусгай зориулалттай материал | 1.3 | 32.7 | 31.4 |
| Эм боох материал | 0 | 55.9 | 55.9 |
| Бичиг хэргийн материал | 0.3 | 0.3 | 0.0 |
| Аж ахуйн материал | 19.6 | 23.9 | 4.3 |
| Түлш, шатах тослох материал | 0.6 | 0.6 | 0.0 |
| Барилгын засварын материал | 0.0 | 1.5 | 1.5 |
| Хүнсний материал | 29.1 | 36.3 | 7.2 |
| Бусад хангамжийн материал | 107.8 | 136.3 | 28.5 |
| Мал амьтад | 6.3 | 5.9 | -0.4 |
| **ДҮН** | **165.1** | **293.3** | **128.3** |

**Бараа материал**




Тайлант онд бараа материалын үлдэгдэл тусгай зориулалтын материал, эм боох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал, хүнсээр нэмэгдсэн байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1655.9 сая төгрөгөөр өссөн байна.

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Барилга, байгууламж, орон сууц | 5823.0 | 6375.6 | 552.5 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 289.0 | 340.0 | 50.9 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 267.3 | 947.3 | 680.1 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 202.5 | 268.6 | 66.1 |
| Бусад үндсэн хөрөнгө | 526.0 | 818.1 | 292.1 |
| Ном | 63.8 | 66.9 | 3.1 |
| Програм хангамж | 6.9 | 6.9 | -0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 112.2 | 123.3 | 11.1 |
| **Дүн** | **7290.7** | **8946.6** | **1655.9** |

Есөнзүйл сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 2137.4 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 70.3 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 2067.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 481.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 0.7 | 9.1 | 8.5 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 87.5 | 87.5 |
| **Дүн** | **0.7** | **96.7** | **96.0** |

**Өглөг**



## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 56.7 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 616.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 16.2 | 11.2 | -5.1 | 69 |
| Хөрөнгийн албан татвар буу | 2.1 | 1.1 | -1.0 | 54 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1.5 | 0.7 | -0.8 | 47 |
| Хог хаягдлын хураамж | 5.6 | 7.0 | 1.4 | 124 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 1.0 | 1.9 | 0.9 | 186 |
| хадгаламжийн хүүгийн орлого | 16.1 | 19.3 | 3.2 | 120 |
| хүү торгуул | 12.9 | 24.9 | 12.1 | 194 |
| ан агнуурын орлого | 0.0 | 501.5 | 501.5 | |
| Газрын төлбөр | 1.3 | 1.4 | 0.0 | 102 |
| малын албан татвар | 0.0 | 47.5 | 47.5 | |
| **Нийт дүн** | **56.7** | **616.4** | **559.7** | **1087** |

### 3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2 тэрбум 873.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 1490.3 сая төгрөг, 971.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32.1 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас 380.0сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 2735.5 сая төгрөг бүрдүүлжээ. Үүнд: 1490.3 сая төгрөгийг улсын төсөв тусгай зориулалтын шилжүүлгээс, 1071.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 30.5 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 142.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 2441.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 115.1 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 61.7 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 41.4 сая төгрөгийг зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 238.5 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 197.3 сая төгрөг, тэтгэмж урамшуулалд 41.2 сая төгрөг зарцуулжээ.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Есөнзүйл сумын Төрийн сан нь 2021 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 0 мэдээллийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд зөрчил илрээгүй.

**3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол**

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

**4. Аудитын илрүүлэлт**

Есөнзүйл сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчил илрээгүй.

**4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар**

Аудитад хамрагдсан 10 байгууллагын 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамруулсан. Эрсдэлээс хамгаалах сан, сумын Еренхий орлогын дансыг аудитад хамруулаагүй. Есөнзүйл сумын Цэцэрлэгт хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 78.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 28.0 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 4.4 сая төгрөгийн зөрчилд акт, 46.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7 зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.

*-ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг / ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Цэцэрлэг, ЕБС/ зөрчиж автомашин, нормын хувцас, тавилга эд хогшил бэлтгэж, уралдаан тэмцээн зохион байгуулсан байна.*

- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа зөрчил илэрсэн. Үүнд:*
  ***Соёлын төв-**Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас багаж хэрэгсэл худалдан авсан, урсгал засварын зардлаас баллонтой цэвэр ус худалдан авсан*
  ***ОНХС-**Өвс тэжээл аваад шууд зардлагдсан 10.0 сая төгрөгийг авлагаар тусгаж залруулсан*
  ***Цэцэрлэг-**2019 онд гэрээгээр мах нийлүүлж байсан "Дэлгэрэх булгийн хишиг" хоршоонд мөнгөө урьдчилж шилжүүлэн махаа суваргаж авч байсан ч цар тахалтай холбоотой үйл ажиллагаа зогсож, үлдэгдэл 4390.1 мянган төгрөгийн махаа одоог хүртэл авалгүй 2 жил болсон байна. Мөнгийг нь шилжүүлээд махаа аваагүй байж хүнсний тайланд орлого авсан. Хүүхдийн хоолны үлдэгдэл оны эхэнд 12473.1 мянган төгрөг байхад 14661.7 мянган төгрөгийн хүнс нэмж орлого аваад 11317.9 мянган төгрөгийг хоолонд зарцуулж 15938.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь хүүхдийн хоолны зардлыг үр ашиггүй, хяналтгүй зарцуулж иржээ. Хүнсний үлдэгдэл ихээр нөөцлөгдөж байгаа нь хүнсний чанар байдал, хадгалалтын хугацаа дуусч хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй байна.*
  ***ЗДТГ-**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж мөрдөөгүй байна.*
  ***ЭМТөв-**Эд хариуцагчийн тайлан дутуу гаргасан. Байгууллагад өгөх өр авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан.*
- ***Дотоод хяналт хариуцлагатай холбоотой зөрчил илэрсэн.***
  ***Соёлын төв-** Байгууллагын дотоод хяналтын нэгж байхгүй.*
- ***Шилэн дансанд мэдээлэл хугацаа хоцорсон зөрчил илэрсэн байна.** Үүнд: ЕБС. Цэцэрлэг*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Есөнзүйл сумын Төрийн сан | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 16 -НЫ ӨДӨР